

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

ТУЗ-ийн даргыг сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1 дэх хэсэг, компанийн дүрмийн 8.8 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Улсын их дэлгүүр” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн ээлжит хурлаар тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр сонгосонтой холбогдуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Янсанжавын Навааныг улируулан сонгосугай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу удирдан зохион байгуулж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА

ТУЗ-ИЙН ГИШҮҮН

ТУЗ-ИЙН ГИШҮҮН

ТУЗ-ИЙН ГИШҮҮН

ТУЗ-ИЙН ГИШҮҮН

ТУЗ-ИЙН ГИШҮҮН

ТУЗ-ИЙН ГИШҮҮН



Я.НАВААН

А.НОРСМАА

Т.САРАНТУЯА

Х.ЭРДЭНЭБААТАР

Т.АМАРТӨР

Н.ЭНХЧИМЭГ

М.ГАНЦЭЦЭГ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

ТУЗ-ийн дэргэдэх хороодыг байгуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2 дахь хэсэг, компанийн дүрмийн 10.1 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Улсын их дэлгүүр” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны ээлжит хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр сонгосонтой холбогдуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд дараах хороодыг байгуулан ажиллуулсугай. Үүнд:
 - 1.1. Аудитын хороо,
 - 1.2. Нэр дэвшүүлэх хороо,
 - 1.3. Цалин, урамшууллын хороо.
2. ТУЗ-ийн дэргэдэх хороодын гишүүдээр дараах нэр бүхий хүмүүсийг сонгосугай. Үүнд:
 - 2.1. Аудитын хорооны гишүүдээр М.Дамирансүрэн, Н.Энхчимэг, А.Норсмаа нарыг.
 - 2.2. Нэр дэвшүүлэх хорооны гишүүдээр Я.Наваан, М.Дамирансүрэн, М.Ганцэцэг нарыг.
 - 2.3. Цалин, урамшууллын хорооны гишүүдээр Н.Энхчимэг, М.Ганцэцэг, Т.Амартөр нарыг.
3. ТУЗ-ийн дэргэдэх хороодын даргыг тухайн хорооны гишүүдийн олонхийн саналаар сонгон баталгаажуулсугай.
4. Холбогдох хууль тогтоомж, компанийн дүрэм, бусад дүрэм журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг шинээр сонгогдсон хороодын дарга, гишүүдэд даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Я.НАВААН